



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 350

Улаанбаатар хот

### Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 3.3, 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мон бийф” ХХК-ийн нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 214,285,700 /хоёр зуун арван дөрвөн сая хоёр зуун наян таван мянга долоон зуу/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/-т, төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Мон бийф” ХХК-ийн нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 150,000,000 /нэг зуун тавин сая/ ширхэг хувьцааны өмчлөх эрхийг энэ тогтоолын хавсралтад заасан хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд баталгаажуулан бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 64,285,700 /жаран дөрвөн сая хоёр зуун наян таван мянга долоон зуу/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар нэг бүрийн үнийг 45 /дөчин тав/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Мон бийф” ХХК /Н.Ариунбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг үнэт цаасны танилцуулгад тусгасан нөхцөлөөр анхдагч зах зээлд худалдахыг “Апекс капитал ҮЦК” ХХК /Б.Лхамдолгор/-д зөвшөөрч, олон нийтэд танилцуулах, сурталчлах болон хувьцааны захиалгыг эхлүүлэхээс ажлын 3-аас доошгүй өдрийн өмнө Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэхийг үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын 3-д заасан нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг 100 /нэг зуу/ хувь худалдсан тохиолдолд үнэт цаасыг анхдагч зах зээлд нээлттэй худалдах ажиллагаа амжилттай болсонд тооцохыг “Мон бийф” ХХК /Н.Ариунбаатар/-д мэдэгдсүгэй.

6. Санхүүгийн зохицуулах хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

7. Энэ тогтоолын 2-т заасан хувьцаа эзэмшигчийн эзэмшилд буй хувьцааг 6 сарын хугацаанд тусгаарлахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоолын 5-д заасан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Апекс капитал ҮЦК” ХХК /Б.Лхамдолгор/-д анхааруулсугай.

9. “Мон бийф” ХХК нь нээлтэй хувьцаат компани болж байгаатай холбогдуулан компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Мон бийф” ХХК /Н.Ариунбаатар/-д үүрэг болгосугай.

10. Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Апекс капитал ҮЦК” ХХК /Б.Лхамдолгор/, “Таван богд капитал ҮЦК” ХХК /Г.Мөнх-Эрдэнэ/, “Өмгөөллийн Эм Жэй Эл атторнейс” ХХН /М.Мөнхжаргал/, “Өмгөөллийн хаан лекс партнерс” ХХН /И.Учралбаяр/, “Эс Жи Эм Ди Аудит” ХХК /Д.Эхбаяр/, “Итгэлт-Эстимэйт” ХХК /Э.Ганбаатар/-д тус тус анхааруулсугай.


11. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн  
350 дугаар тогтоолын хавсралт



№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Хувьцааны тоо ширхэг
1	“Таванбогд трейд” ХХК		112,500,000
2	Ж.Барсболд		15,000,000
3	Ц.Цэцэнхүү		7,500,000
4	Э.Пүрэвлхам		7,500,000
5	И.Багтуяа		4,500,000
6	Ж.Оюунчимэг		3,000,000
	Нийт дүн		150,000,000